

Байгаль орчны зөвлөх үйлчилгээ, судалгаа, үнэлгээ



Дорнод аймгийн Баяндун сумын
нутагт орших Мухарт, Тавхайн амны
алтны шороон ордыг ил аргаар
ашиглах төслийн байгаль орчны
менежментийн төлөвлөгөө
2025

Улаанбаатар
2025 он

ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ТӨСЛИЙН НЭР :

Мухарт, Тавхайн амны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ :

“Алтан дун дорнод монгол” ХХК,

Улсын бүртгэлийн дугаар: 9011820477

Регистрийн дугаар: 6604277

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар : MV-022752

Гүйцэтгэх захирал: Б.Баасанбямба

Утас: 94561287

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19-р хороо, Чингүнжав, 54а тоот

ТӨСЛИЙН БАЙРШИЛ:

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт Баяндун сумаас 25 км, Дашбалбар сумаас 85 км, Чойбалсан хотоос 240 км, Улаанбаатар хотоос 700 км-ийн зайд байрлана. .

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ:

Төсөл хэрэгжих талбай нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт байрлах ба АМГТГ-аас 2021 оны 04 сарын 09-ний өдрийн шийдвэрээр XV-021760 тоот “Чулуут” нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийг “Арвинцайдам” ХХК авсан бөгөөд “Алтан дун дорнод монгол” ХХК нь 2022 оны 09 сарын 02-ны 15 тоот шийдвэрээр шилжүүлэн авсан.

Улмаар 2022 онд хийж гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр 2024 оны 1-р сарын 26-ы өдөр MV-022752 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН:

2025 онд Байгаль орчны үнэлгээний “Саблайм” ХХК-аар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулж батлуулсан.

Мухарт, Тавхайн амны алтны шороон ордыг ТЭЗҮ-д тусгаснаар ордыг ашиглах хугацаа 2 жил, нөхөн сэргээлт хаалтыг 2026 буюу 2 дахь жилээс хийхээр төлөвлөсөн байна. Орд ашиглалтын 2 жилийн хугацаанд 48.89 га талбайгаас 195.57 мян.м3 шимт хөрс хуулах ба 6.86 га талбайд байршина

Мухарт, Тавхайн амны ордын тусгай зөвшөөрлийн талбайн нийт хэмжээ 349.98 га. Газарзүйн 1:100,000-ны номенклатурын М-49-85 хавтгайд байрлана.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ:

АМГТГ-ын даргын 2024 оны 7-р сарын 30-ны өдрийн т/127 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2024 оны 6-р сарын 19-ны өдрийн т/24-19-08 тоот дүгнэлт батлагдсан. Тус ордыг алттай элсний давхаргын хажуугаас мөн ул болон таазнаас бохирдуулж олборлох ба бохирдлын нийт хэмжээ 19% буюу 36.85 мян.м3, олборлолтын явцад хаягдал үүсэхээргүй тооцож, бохирдол тооцсон бөгөөд геологийн бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' зэрэглэлд шилжүүлэн тооцоноор нийт ордын хэмжээнд химийн цэврээр 34.65 кг алт агуулсан 231.31 мян.м3 элс олборлохоор ТЭЗҮ-д тооцжээ. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 1,049.91 мян.м3 хөрс хуулалт хийж, жилд хамгийн ихдээ 157.2 мян.м3 элс олборлох хүчин чадалтайгаар 2 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

Хүчин чадал: Уурхайн ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 1,281.22 мян.м3 уулын цул үүнээс 231.31 мян.м3 элс олборлож, 1,049.91 мян.м3 хөрс хуулна

Ажиллах хүчин: Төслийн хугацаанд хамгийн ихдээ 24 хүн байрлана ажилтан ажиллах бөгөөд жилд хоногт 2 ээлжээр 145 хоног ажиллана.

Хүснэгт 1. Уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	I жилд (2025)	II жилд (2026)
1	Календарийн хоног	хоног	150	211
2	Баяр ёслол, амралтын өдрүүд	хоног	5	7
3	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	5	14
4	Уурхайн жилд ажиллах бодит хоног	хоног	145	190
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2	2
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	12
7	Ээлжийн сул зогсолт (цайны цаг)	цаг	1	1

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	I жилд (2025)	II жилд (2026)
8	Ээлжийн сул зогсолт (ээлж солилт, түлш тос солилт)	цаг	1	1
9	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.84	0.84
10	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	20	20


Уурхайн хүчин чадлаас хамааруулан ордын олборлолтын ажлыг хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Уурхайн 2025 онд хөрс хуулалтын ажлыг 7-р сараас 11-р сар хүртэл, элс угаалтын ажлыг 9-р сараас эхлэн 10-р сарыг дуустал, 2026 онд хөрс хуулалтын ажлыг 4-р сараас 11-р сар хүртэл, элс угаалтын ажлыг 5-р сараас эхлэн 10-р сарыг дуустал үргэлжлэхээр тооцсон байна.

1.2.1. Элс олборлолтын төлөвлөгөө

Мухарт, Тавхайн амны алтны шороон ордыг ашиглалтын 2026 онд 231.31 мян.м³ элс олборлох ба үүнээс ашиглалтын эхний жилд 74.11 мян.м³, ашиглалтын 2 дахь жил буюу 2026 оноос 157.2 мян.м³ элс тус тус олборлоно.

Зураг 2. Ил уурхайн технологийн процесс



1.2.3. Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ордын уулын ажлын календарчилсан төлөвлөлтийг ордын уул геологийн нөхцөл, элс угаан баяжуулах хэсгийн хүчин чадал болон олборлолтод ажиллах техникүүдийн хүчин чадалд тулгуурлан боловсруулсан байна. Ил уурхай нь ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 1,281.22 мян.м³ уулын цул үүнээс 231.31 мян.м³ элс олборлож, 1,049.91 мян.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын коэффициент 4.5 м³/м³ байна.

Хүснэгт 2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	I жилд (2025)	II жилд (2026)	Нийт
Ил уурхай					
1	Үржил шимт хөрс хуулалт	мян.м ³	24.03	49.31	73.34
2	Хөрс хуулалт	мян.м ³	364.06	612.51	976.57
3	Нийт хөрс	мян.м ³	388.09	661.83	1049.91
4	Элс олборлолт	мян.м ³	74.1	157.2	231.31
5	Уулын цул	мян.м ³	462.20	819.03	1281.22
6	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	5.24	4.21	4.54
Баяжуулах цех					
1	Угаах элсний хэмжээ	мян.м ³	74.1	157.2	231.31
2	Дундаж агуулга	мг/м ³	198.41	180.09	185.96
3	Бүтээгдэхүүн гаргалт	Шлих	кг	28.31	43.01
4		Химийн цэврээр	кг	22.63	34.65

1.2.4. Уурхайн тоног төхөөрөмж

Тус ордыг компани өөрийн техникээр олборлоно.

Хүснэгт 3. Ил уурхайд ажиллах үндсэн техникийн тоо

№	Тоног төхөөрөмж	Марк	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	Тоо ширхэг	
						I жилд (2025)	II жилд (2026)
1	Экскаватор	Hyundai-520 lc-9A	Утгуурын багтаамж	м ³	3.2	1	1
2	Экскаватор	Hyundai-300	Утгуурын багтаамж	м ³	1.2	-	1
3	Утгуурт ачигч	XZ 656 L	Утгуурын багтаамж	м ³	3.0	1	1
4	Бульдозер	65D65	Хусуурын хамах чадвар	м ³	6.0	1	1
5	Автосамосвал	336	Техникийн даац	тн	15	2	4
6	Гэрэлт цамхаг	Terex RL 4	Хөдөлгүүрийн чадал	кВт	6	1	1

1.2.5. Баяжуулах технологи

Угаан баяжуулах хэсгийн технологийн горим

Шлюзийн технологиор лабораторийн нөхцөлд энгийн шлюзээр баяжуулахад металл авалт 84.79% байна. Торын шинжилгээнээс үзэхэд 0.125 мм-ээс их фракцын алт 97.49% байгаа нь алтны баяжигдах чанар сайтай бөгөөд үйлдвэрлэлийн угаах төхөөрөмжөөр баяжуулах боломжтой гэж үзэж байна.

1.3.Дэд бүтэц

1.3.1.Уурхайн барилга байгууламж

Уурхайн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр багтах бөгөөд эдгээр нь уурхайгаас урд зүгт 600 м зайд байрлана. Эдгээр барилга байгууламжуудыг 2018 онд ашиглалтад оруулсан. Төслийн хугацаанд хамгийн ихдээ 24 хүн байрлана.

Хүснэгт 4. Уурхайн барилга байгууламж

№	Нэр	Хийц бүтэц	Тоо хэмжээ, ш
1	Захиргааны байр	Контейнер	1
2	Ажилчдын байр	Гэр	8
3	Хоолны байр	Сэндвичэн барилга	1
4	Халуун усны байр, хувцас угаалга	Контейнер	1
5	Нийтийн бие засах газар	Модон	1
6	Эмнэлэг	Гэр	1
7	Хүнсний агуулахууд	Гэр	1

Зураг 3. Одоогийн уурхайн кемп



1.3.2.Цахилгаан хангамж

Ил уурхай, угаан баяжуулах цех болон бусад ашиглалтын туршид дараах цахилгаан хэрэглэгчид байна.

1. Угаан баяжуулах цех
2. Засварын газар
3. Уурхайн хотхон
4. Шатахуун түгээх станц

Уурхайн цахилгаан хангамжийг ДС-200 дизель станц 1 ш хангана.

Зураг 4. Дизель генератор



1.4 Усан хангамж

Ордын гидрогеологийн нөхцөл

Судалгаа явуулсан талбайн дөрөвдөгчийн хурдасны газрын доорх ус нь ихэвчлэн агаарын хур тунадсаар тэжээгдэнэ. Гидрогеологийн туршилтыг ашиглан техник хэрэгсэл хугацааг харгалзан зөвхөн дөрөвдөгчийн хурдасны уст үед явуулав. Гидрогеологийн параметруудийг тодорхойлох зорилгоор цагаан чулуутыг гидрогеологийн 4 цооногийг өрөмдөв. Өрөмдлөгөөр дөрөвдөгчийн хурдасны зузааныг өрөмдөж үндсэн чулуулагт 6-8м гүнтэйгээр өрөмдсөн болно. Ц-71-р цоогийн ул чулуу нь улаан хүрэн өнгийн конгломерат байв.

Хүснэгт 5. Нийт усны хэрэглээ


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жил		Нийт
			1	2	
1	Унд ахуйн ус хэрэглээ	мян.м3	1.17	1.54	2.71
2	Үйлдвэрийн технологийн усны хэрэглээ	мян.м3	56.69	120.26	176.94
3	Нөхөн сэргээлтийн усалгаа	мян.м3	4	20.4	24.38
4	Тоосжилт дарах усалгаа	мян.м3	79.2	120.0	199.20
Нийт		мян.м3	141.1	262.2	403.24
Үүнээс: Хоногт					
1	Унд ахуй	м3/хон	8.1	8.1	16.2
2	Технологийн ус	м3/хон	0.6	0.6	1.2
3	Нөхөн сэргээлтийн усалгаа	м3/хон	50	104.0	154.0
4	Тоосжилт дарах усалгаа	м3/хон	13.2	20	33.2
Нийт		м3/хон	71.9	132.7	204.6

1.5 Нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг тогтоох арга зүй, үнэлгээ

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 4-р сарын 10-ы өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу нөлөөлөлд өртөх газрын хэмжээг төслийн үйл ажиллагаатай уялдуулж тооцно.

Амьдрах орчинд үзүүлэх төслийн нөлөөллийн индексийг тооцоолох ГМС дээр тулгуурласан “Нөлөөлөл орон зайд буурах функц”-ийг ашиглан нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоож болно. энэ арга нь шууд ба шууд бус нөлөөллийг орон зайн хувьд хэмжиж болон хялбар арга юм. Энэ нь ялангуяа дүйцүүлэн хамгаалах газар нутгийн хэмжээг нөлөөлөлд өртсөн амьдрах орчинтой харьцангуйгаар тодорхойлоход чухал юм.

Зураг 5. Төслийн нөлөөллийн хүрээ



Хүснэгт 6. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн чиглэл

№	Нөхөн сэргээх чиглэл	Ашиглах хэлбэр
1	Хөдөө аж ахуй	Бэлчээр, хадлан, тариалан
2	Ойн аж ахуй	Ойжуулалт, мод үржүүлэг
3	Усны аж ахуй	Усан сан, усжуулалт
4	Тусгай зориулалт	Аялал жуулчлал, амралт
5	Байгаль хамгаалал	Ургамалжуулалт, ойжуулалт
6	Барилга, хаягдал	Барилга, хаягдлын талбай

1.5.1 Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ

“Алтан дун дорнод монгол” ХХК -ийн MV-022752 Дорнод аймгийн Баяндун сумын нутагт Баяндун сумаас 25 км, Дашбалбар сумаас 85 км, Чойбалсан хотоос 240 км, Улаанбаатар хотоос 700 км-ийн зайд байрлана.

Зураг 6. Төсөл хэрэгжих талбай



1.7 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ

“Алтан дун дорнод монгол” ХХК -ийн MV-022752 тоот лиценз нь 349.98 га талбайг эзэмшдэг бөгөөд үүнээс ашиглалтын 2 жилийн төгсгөлд ойролцоогоор 48.9 га газар нөлөөлөлд өртөхөөр байна.

Олборлолтын явцад нийт 6 метрийн гүнтэй ил уурхайн ухаш үүсэх

Хүснэгт 7. Эвдрэлд өртөх талбайн хэмжээ

№	Талбай	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд		Нийт
			I жилд (2025)	II жилд (2026)	
1	Ил уурхай	га	7.7	15.5	23.25
2	Гадаад хөрсний овоолго байрших талбай	га	2.1	1.5	3.63
3	Шимт хөрсний овоолго байрших талбай	га	2.7	4.2	6.86
4	Баяжуулахын талбай	га	1.9	1.9	3.75
5	Технологийн зам	га	5.5	5.9	11.41
	Нийт	га	19.9	29.9	48.9

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Дорнод аймгийн Баяндун сумын нутаг орших Мухарт, Тавхайн амны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь :

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	НИЙТ 2025он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	мян.төг	2,125.0
2	Нөхөн сэргээлт, хаалтын ажлын зардалд	мян.төг	4,000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	5,723.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	-*-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	-*-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	мян.төг	2,050.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	мян.төг	1,450.0
8	Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	мян.төг	-*-
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	мян.төг	1,928.0
10	БОМТ -г орон нутагт тайлагнах	мян.төг	1,000.0
11	Тэрбум мод тарих төлөвлөгөөний зардал	мян.төг	5,862.5
	Дүн	мян.төг	24,138.50

Төсөл хэрэгжүүлэгч “Алтан дун Дорнод Монгол” ХХК нь “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэрээт байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Цаашид ашиглалтын жил бүр 200 мод тарихаар төлөвлөв. /БОХТ-нд зардлыг тусгаж өгөв.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Алтандун дорнод монгол” ХХК -аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОУАӨЯ -аас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн “Алтандун дорнод монгол” ХХК -аас Мухарт, Тавхайн амны алтны шороон ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхэд зориулагдсан болно.

Төслийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОХТ -ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, агаар, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

БОХТ -ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх, БОХТ -ний биелэлтийг дүгнэхдээ жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх ёстой.

БОХТ -ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 01 -ний дотор БОУАӨЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

1.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААРЫН ОРЧИН						
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох	Уурхайн талбайн хэмжээгээр	Үйл ажиллагааны зардал	Сар бүр	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны
2		Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ тогтмол авч байх	Угаан баяжуулах хэсэг	120.0	Өдөр бүр хяналт тавих	
3		Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээг авах	Үйл ажиллагааны турш	150.0	Улиралд 1 удаа	
5	Ил уурхайн олборлолт болон хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болно.	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийнэ.	Уурхайн талбайн хэмжээгээр	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Замын засварыг улиралд 1 удаа Усалгааг 7 хоног болгон	
6		Салхи ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах		Үйл ажиллагааны зардалд тусгасан	Цаг уурын нөхцөлөөс шалтгаална	
7		Дотоод болон гадаад тээврийн замыг салхи ихтэй, хуурайшилттай өдрүүдэд услах		Үйл ажиллагааны зардалд тусгасан	Сард 1 удаа буюу тээврийн замын хэмжээнээс шалтгаалан 7	

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
					хоногт хуваан услах	ерөнхий шаардлага
8		Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.		Үйл ажиллагааны зардалд тусгасан	Өдөр бүр	MNS ISO 226:2003 Дуу
9		Овоолго болон барилгын ажлын үед тоосжилт үүсгэж болзошгүй талбайнуудад усалгаа хийнэ	Уурхайн ашиглалтын талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Сард 1 удаа буюу ажлын хэмжээнээс шалтгаалан 7 хоногт хуваан услах	чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
Дүн				625.0		
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
11	Хөрсний үржил шим алдагдах	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Үйл ажиллагааны турш	Уулын ажлын зардлаас	Төсөл хэрэгжих хугацаанд	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Газрын тухай хуулийн 50.1.1 MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
12		Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	Шимт хөрсний овоолгод	Нөхөн сэргээлтийн зардалд орсон	Эхний жилээс эхэлнэ	
13		Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хориглох, тогтсон маршрутаар зорчуулах	Уурхай хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд орсон	Өдөр бүр	
14		Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	Төсөл хэрэгжих талбайд	400.0	2025 онд	
15	Уурхайн үйл ажиллагаа улмаас газрын гадарга эвдэрч	Уурхайн тосгоны тоосжилтын бууруулж, мод, бут тарих, зүлэгжүүлэх	Барилга байгууламжаас бусад талбай	Нөхөн сэргээлтийн зардалд орсон	2025-2026	

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	хөрсөн бүрхэвч устгах					MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
17	Ахуйн хаягдал, шатах, тослох материал	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдал гэх мэт аюултай хог хаягдлын бүртгэл гаргах	Үйл ажиллагааны турш	150.0	Өдөр бүр	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
18	алдагдах, баяжуулах үйлдвэрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох	Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах, ариутгах зайлуулах,	Үйл ажиллагааны турш	250.0	Өдөр бүр	
Дүн				800.0		
ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС						
1	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх, ус хэмнэлтийн менежментийг хэрэгжүүлэх	Уурхайн ажилчид	250.0	Өдөр бүр	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОНБНҮ, Компанийн дотоод журам,

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
						Усны менежментийн төлөвлөгөө
2		Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулж	Уурхайн талбайн хэмжээнд	250.0	Жил бүр	
3		Эргэлтийн усан сангийн чанарын үзүүлэлтийг хяналт тавих	Эргэлтийн усан санд	Орчны хяналт шинжилгээний зардалд	7, 9-р сард	
4	Газрын доорх ус	Гүний усны чанарын үзүүлэлтийг шинжлүүлж, хяналт тавих	Уурхайн гүний худагт	Орчны хяналт шинжилгээний зардалд	7, 9-р сард	
	Дүн			500.0		
АМЬТНЫ АЙМАГ						
1	Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүн болон автомашины хөл хөдөлгөөн, дуу чимээнээс амьтад дайжих	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, хяналт тавих	Төслийн талбайн ойр орчимд	200.0	Төсөл хэрэгжих хугацаанд Жилд 1 удаа	Амьтны тухай хууль
	Дүн			200.0		
	НИЙТ			2,125.0		

1.1.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Мухарт, Тавхайн амны алтны шороон ордын нөхөн “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцоолно.

Хүснэгт 10. Техникийн нөхөн сэргээлтийн зардал

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Нийт, сая.төг 2025
Техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардал			
1	Шимт хөрсөөр хучих ажлын ачих зардал	сая.төг	1.9
2	Тараасан хөрсийг тэгшлэх ажлын зардал	сая.төг	3.8
3	Эвдрэл өртсөн талбайд хэвгийжүүлэх, дэвсгэгжүүлэх хийх ажлын зардал	сая.төг	7.7
4	Шимт хөрсийг хадгалах, хамгаалах зардал	сая.төг	4.0
Техникийн нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал		сая.төг	17.4

Хүснэгт 11. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын дүн

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Нийт, сая.төг 2025 он
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал			
1	Хөрсжүүлэх	сая.төг	3.9
2	Бүрхэвч ургамал тарьж суулгах	сая.төг	4.1
3	Олон наст ургамлын үр тарьж суулгах /моджуулах/	сая.төг	-
4	Нөхөн сэргээсэн талбайг хамгаалах ажлын зардал	сая.төг	3.0
5	Мониторингын ажлын зардал	сая.төг	-
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал		сая.төг	11.0

Жижиг алтны шороон ордын 2 жилийн ашиглалтын хугацаанд эвдэрч болзошгүй 48.9 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөт хугацаанд, унаган төрхийг аль болох хадгалах зарчмаар, мэргэжлийн байгууллагууд болон орон нутгийн оролцоотойгоор хэрэгжүүлэхээр тусгалаа.

1.1.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн MV-022752 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

1.1.4 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

1.1.5 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг.

Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Дүйцүүлэн хамгаалах зардлыг тодорхойлох

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөгөөг гаргасан байх бөгөөд ингэхдээ төсөл хэрэгжүүлэгч тал дүйцүүлэн хамгааллын жилийн төсвийг тооцоолох, санхүүжилт хийхэд 2 жилийн санхүүгийн төлөвлөлтийг үндэслэж гаргана. Үүнд:

- ✓ Нэмэлт судалгааны зардал
- ✓ Хамгааллын арга хэмжээг төлөвлөх зардал
- ✓ Хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх зардал зэрэг багтана.

Дүйцүүлэн хамгаалах зардлын хэмжээг тодорхойлох

Хүснэгт 12. Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Ашиглалтын 1-р жил 2025	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж		Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
			Сая.төг			
	Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалах ажиллагааны ургамлын нарийвчилсан судалгааг хийх	0.8	Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон талбайд	2025 онд	-
		Ховрын статустай ургамлыг дүйцүүлэн хамгаалах газарт шилжүүлэн суулгах, тарималжуулах	1.6		Төсөл хэрэгжих хугацаанд (2025-2026)	
		Амьтны аймгийн судалгааг нарийвчлан хийх	0.6			
		Мониторингийн хяналтын цэгийг тогтоож тогтмол хяналт тавих	-			
	Амьтдын тоо толгой буурах, дайжих амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомсдохоос хамгаалах	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	-	Үйл ажиллагааны турш	Төслийн бүх үе шатанд (2025-2026)	Амьтны тухай хууль
		Амьтдын амьдрах орчинд биотехникийн арга авах	1.3	Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон талбайд		
		Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах	1.4	Үйл ажиллагааны турш	Төслийн бүх үе шатанд (2025-2026)	Усны тухай хууль
		Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	0.9	Үйл ажиллагааны турш	Төслийн бүх үе шатанд (2025-2026)	-
			6.6	НИЙТ 6.6 сая.төг		

Хүснэгт 14. Экосистемийн ангилал.

	Экосистемийн ангилал					
	Маш ховор(3)		Ховор(1.5)		Хэвийн(0.2)	
Нөлөөллийн эрчим	Жинхэнэ (га)	ДХН	Жинхэнэ (га)	ДХН	Жинхэнэ (га)	ДХН
Их -1	0	0	0	0	675.45	73
Дунд-0.66	0	0	0	0	250.76	21
Бага-0.33	0	0	0	0	676.88	25
Дүйцүүлэн хамгааллын нийт нэгж= 67						

Хүснэгт 15. Амьдрах орчны төрөл

	Амьдрах орчны ангилал					
	Чухал(3)		Хэвийн(1.5)		Өөрчлөгдсөн(0.2)	
Нөлөөллийн эрчим	Жинхэнэ (га)	ДХ нэгж	Жинхэнэ (га)	ДХ нэгж	Жинхэнэ (га)	ДХ нэгж
Их -1	675.45	326	0	0	0	0
Дунд-0.66	250.76	114	0	0	0	0
Бага-0.33	676.88	261	0	0	0	0
Дүйцүүлэн хамгааллын нийт нэгж= 701						

Хүснэгт 16. Экологийн эрүүл байдал

	Экологийн эрүүл байдал					
	Сайн(3)		Дунд(1.5)		Муу(0.2)	
Нөлөөллийн эрчим	Жинхэнэ (га)	ДХ нэгж	Жинхэнэ (га)	ДХ нэгж	Жинхэнэ (га)	ДХ нэгж
Их -1	0	0	0	0	675.45	73
Дунд-0.66	0	0	0	0	250.76	21
Бага-0.33	0	0	0	0	676.88	25
Дүйцүүлэн хамгааллын нийт нэгж= 67						

Хүснэгт 17. Ландшафтын байршил

	Ландшафтын байршил					
	Чухал(3)		Дунд(1.5)		Чухал бус(0.2)	
Нөлөөллийн эрчим	Жинхэнэ (га)	ДХ нэгж	Жинхэнэ (га)	ДХ нэгж	Жинхэнэ (га)	ДХ нэгж
Их -1	675.45	326	0	0	0	0
Дунд-0.66	250.76	114	0	0	0	0
Бага-0.33	676.88	261	0	0	0	0
Дүйцүүлэн хамгааллын нийт нэгж= 701						

Хүснэгт 19. Төслийн үргэлжлэх хугацаа

	Үргэлжлэх хугацаа	
	Богино(2)	
Нөлөөллийн эрчим	Жинхэнэ (га)	ДХ нэгж
Их -1	675.45	73
Дунд-0.66	250.76	21
Бага-0.33	676.88	25
Дүйцүүлэн хамгааллын нийт нэгж= 67		

Хүснэгт 20. Дүйцүүлэн хамгаалахад шаардлагатай хэмжээ

№	Хүчин зүйл	Талбайн хэмжээ, нэгж
1	Амьдрах орчны төрөл	701
2	Экосистемийн ховор байдал	67
3	Экологийн эрүүл байдал	67
4	Ландшафтын байршил	701
5	Нөлөөллийн хугацаа	67
Нийт		1603

Дүйцүүлэн хамгаалах нийт нэгж: 1603

$1603.09 \times 3570 \text{ төгл} = 5,723,031.3 \text{ төгрөг} / 1\$ = 3570 \text{ төг}$

Хүснэгт 21. Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 22.

№	Нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
		2025 I жил			
1	Улиас мод	200	ш	2,500.00	500,000.00
2	Нүх ухах	200	ш	2,750.00	550,000.00
3	Усалгаа	2	ш	375,000.00	750,000.00
4	Тээврийн зардал	3	Өдөр	125,000.00	375,000.00
5	Хар шороо	5	м3	100,000.00	500,000.00
6	Элс	4	м3	75,000.00	300,000.00
7	Бууц	1.5	м3	125,000.00	187,500.00
8	Талбай цэвэрлэх	1	ш	500,000.00	500,000.00
9	Мод тарих зардал	200	ш	1,250.00	250,000.00
	Нийт				3,912,500.00
Арчилгаа					
10	Усалгаа (Зөөврөөр)	2	Удаа	375,000.00	750,000.00
11	Арчилгаа	10	Удаа	120,000.00	1,200,000.00
12	Нийт				1,950,000.00
Нийт зардал					5,862,500.00

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт жилд 200 мод тарихаар нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцсөн. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэрээт байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 23. Байгалийн бүс бүслүүрийн харгалзан тарих мод, бутыг сонгох

№	Байгалийн бүс бүслүүр		Мод, бут
1	Өндөр уулын бүс		Нарс, шинэс, улиас, улиангар, хус, бургас, монос, чацаргана, нохойн хошуу, шар хуайс, боролзгоно, голт бор
2	Уулын тайгын бүс		
3	Ойт хээрийн бүс		
4	Хээрийн бүс	Нугын хээр	Хайлаас, бургас, монос, чацаргана, нохойн хошуу, шар хуайс, боролзгоно, голт бор
		Хээр	
		Хуурай хээр	
5	Говийн бүс	Цөлжүү хээр	Заг, тоорой, жигд, сухай, гүйлс, хармаг
		Заримдаг цөл	
6	Цөлийн бүс	Хээржүү цөл	
		Жинхэнэ цөл	
		Хэт гандуу цөл	

БОМТ-нд мод тарих, арчлах зардлыг тусгаж өглөө. Ашиглалтын жилд 400 мод тарихаар төлөвлөв

Зураг 7. Хайгуул хийх талбайн байршил



1.1.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 24. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Хээрийн түймэр уурхайн талбай, кэмп рүү орж ирэх, уурхайн хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Түлшний агуулах, засварын газар,	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаах дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Дотоод журам	2025-2026 он

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	300.0	Жилд 1 удаа
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр уурхай эхлэх үед
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	_*-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	500.0	Жил бүр, жилд 1 удаа
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	1 250.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жил бүр, жилд 1 удаа

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах			
Нийт зардал		2 050.0	

1.1.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 25. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	300.0		Тогтмол	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	200.0		Тогтмол	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	750.0		Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш			Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	200.0		Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	-	Үйл ажиллагааны зардал		Төсөл хэрэгжих хугацаанд	2025-2026

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	Үйл ажиллагааны зардал		Төсөл хэрэгжих хугацаанд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
НИЙТ ДҮН			1 450.0			

6.1.9 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч “Алтандун дорнод монгол” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах Хамтарч ажиллах	-
БОУАӨЯ-ны ХБОБНУГ, Дорнод аймгийн БОГ-т	Тухайн жилийн БОМТ, тайлан	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-

1.1.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт 26. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрөлтэй талбай	Гэрээний үнийн дүнгээр	Өмнө хийлгэснээс 5 жилийн дараа	Газрын тухай хуулийн 58.5
Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах	Уурхай хаагдахаас 3 жилийн өмнө	--*--	--*--	БОНБУнэлгээний тухай хуулийн 14.1.3-т зааснаар
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	тохиролцох	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Нийт, сая.төг		--*--		

Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Алтандун дорнод монгол” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ -тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Алтандун дорнод монгол” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Алтандун дорнод монгол ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна

Хүснэгт 27. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Уурхайлалт явагдаж буй талбайд	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 4 цэг сонгох	Жилд 2 удаа	78.0 х жилд 2 удаа х 4 цэг НИЙТ 624.0	MNS 4585:2016 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн нийт үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах				
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа хөдөлгөөнөөр шуугиан үүсэх				
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН,	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах	Төслийн талбайд хяналтын 5 цэг	Жилд 2 удаа	5 цэгт х 2 удаа х 20.0 мян.төг	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	цахилгаан дамжуулалт, давс, ялзмагийн агууламж, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд		сонгох /доорх цэгүүдэд/		НИЙТ 200.0 /Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж -20.0 төг,	MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга
	Хүнд металлын агууламж	ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэг, уурхайн олборлолтын хэсэг, замын дээр түлш асгарны улмаар бохирдох		Улиралд 1 удаа жилд 3 удаа/	5 цэгт х 1 дээж х жилд 3 удаа х 33.0 Нийт 495.0 /Хүнд металлын шинжилгээ 1 дээж- 33.0 төг/ Микробиологи 1 цэгт х 1 дээж х жилд 3 удаа х 25. Нийт 75.0 /Эрүүл ахуйн шинжилгээ 1 дээж-25.0 төг/	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
					570.0	
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний усанд	Булаг, эргэлтийн усан сан	Жилд 2 удаа	Усны шинжилгээ 46.0 x 2 цэг x 2 удаа = 184.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2.2	Усны түвшин усны ундарга, нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх		Жилд 2 удаа	Худгийн түвшин хэмжилт 1 булаг x 1 удаа x 50.0 =50.0 НИЙТ 234.0	
Ургамлын аймаг						
3.1	Ургамал устгах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биоамасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 4 цэгт	Жилд 1 удаа	500.0	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					1,928.0	